

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	13
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4 Аудит хийсэн тайлан мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5 Орлого, зардлын гүйцэтгэл	16
5. Зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн Өмчийн Аж Ахуйн Тооцоотой Улсын Үйлдвэрийн Газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ,
БИЗНЕСИЙН КОРПОРАЦИ
ТӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ П.НАСАНЖАРГАЛ
ТАНАА

2020.03.13 № 06/795
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци" ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци" ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Авлага барагдуулаагүй, татварын өр нэмэгдүүлсэн, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй, ажилтнуудын ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйгээс цалин давхардуулан олгосон зэрэг нийт 50.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага


Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, Зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө боловсруулж батлуулж ажиллах тухай зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 25-наас 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Пийк ОМ аудит ХХК-ний аудитор З.Цэцгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 20/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тус байгууллага нь зорилгоо “Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн ирээдүйн хөгжлийн чиг хандлагын технологийн болон бизнес загварчлалын талаар судалгаа хийж яам, салбарын холбоо, аж үйлдвэрийн паркттай хамтран ажиллах, Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслүүдийг хэрэгжүүлэх, өөрийн шинжлэх ухааны чадавхыг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах” гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгын хүрээнд дараах чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Малын гаралтай түүхий эдийг үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болгон боловсруулж гадаад дотоодын зах зээл дээр гаргах үндэсний оюуны чадавхийг хөгжүүлэх;
- Хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажил, зөвлөх үйлчилгээг үзүүлэх, сургалт, үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах;
- Шинжлэх ухаан болон үйлдвэрлэл технологийн паркийг хөгжүүлэх ажилд оролцох
- Салбарын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, семинар зохион байгуулах;
- Хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлого, стратеги боловсруулахад мэргэжлийн байгууллагын зүгээс санал боловсруулж оролцох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 370 тоот тогтоолоор Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны харьяалалд шилжүүлсэн байна.
- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээтэй холбоотой;

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-т мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Covor soft” программ хангамж ашигладаг байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 349.7 сая төгрөгөөс тооцон 3.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөөгүй 5.9 сая төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187.7 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.8	3.6	(0.2)
Авлага	50.7	131.4	80.7
Урьдчилж гарсан зардал	142.0	00.0	(142.0)
Бараа материал	2.9	2.6	(0.2)
Үндсэн хөрөнгө	7,243.7	7,117.8	(125.9)
Нийт хөрөнгө	7,443.1	7,255.4	(187.7)
Өр төлбөр	319.8	117,7	(202.1)
Эздийн өмч	7,123.3	7,137.7	14.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,443.1	7,255.4	(187.7)

Өмнөх оны үзүүлэлтээс урьдчилж төлсөн тооцоо, авлага, өглөгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 80.7 сая төгрөгөөр өссөн нь Шинжлэх ухааны паркийн захиргаа, шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл УТҮГ-аас түрээсийн төлбөрөө төлөөгүйгээс шалтгаалсан байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 142.0 сая төгрөгөөр буурсан нь 2016-2018 онуудад эхэлсэн төслийг хэрэгжүүлэн хүлээлгэн өгч тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7.5 сая төгрөгөөр өссөн нь төслийн үр дүнд бэлтгэгдсэн тоног төхөөрөмжийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 187.7 сая төгрөгөөр буурсан нь урьдчилж орсон орлого данснаас 210.8 сая төгрөгийг тайлант онд борлуулалтаар хүлээн зөвшөөрч тайлагнаснаас шалтгаалжээ. Татварын өр төлбөр 14.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Эзний өмчийн дансны үлдэгдэл 7,137.7 сая төгрөг болж тайлант үеийн цэвэр ашгийн дүн 14.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШИН, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Тус ТӨҮГ нь 2019 оны орлогын төлөвлөгөөг 590.8 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр түрээсийн орлого 374.0 сая төгрөг, шинжилгээний орлого 24.6 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлого 210.8 сая төгрөг нийт 609.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Орлогын төлөвлөгөө 18.7 сая төгрөгөөр давж биелсэн нь байрны түрээсийн орлого байна.

Зардлыг 596.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 593.6 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант жилд цалингийн зардлыг 7.5 сая төгрөгөөр хэмнэсэн, тогтмол зардал 4.3 сая төгрөгөөр хэтэрсэн зэргээс нийт зардлын хэмнэлт 3.2 сая төгрөг байна.

Тайлант онд 14.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 372.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 259.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 49.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 62.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 61.9 сая төгрөгөөр илүү тооцож санхүүгийн тайланд тусгаснаар тайлант үеийн үр дүн, санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

2. Бараа материалын дансаар дамжуулаагүй 2.1 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

3. Орлогын дэлгэрэнгүй тайланд 195.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн зардалд тайлагнаж бүртгэсэн нь Сангийн сайдын 217 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын 3.11-д “Бүх төрлийн хүүгийн зардал, зээлийн шимтгэл, зээлтэй холбоотой үүссэн бусад зардал (тухайлбал, бичиг хэргийн) хамаарна”- гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4. Ээлжийн амралтаа биеэр эдлээгүй ажилтнуудад 1.4 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан *“Ээлжийн амралт олгох заавар”*-ын 13-т *“Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх, төлбөрийн акт тогтоосон.

5. Тайлант онд татварын өр төлбөр өмнөх оноос 14,6 сая төгрөгөөр нэмэгдсэн, Шинжлэх ухааны паркийн захиргаа, шинжлэх ухаан технологи үйлдвэрлэлийн нэгдэл УТҮГ-аас авах 2018-2019 онуудад үүссэн 34.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д *“Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”* гэсэн заалттай нийцээгүй, Санхүүгийн тайлангийн Эрх ба Үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 оноос хойш шинэчлээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Хүвь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.3, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын өөрчлөлтүүдийг тусгаж мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *“Аж ахуйн нээж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн мөрдөх албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн зөрчилд 62.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй, өмч хөрөнгөд тавих дотоод хяналт сайжруулах дараах асуудлуудад байгууллагын удирдлага анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Тухайн байгууллагын нь захирал нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай гэрээ байгуулаагүйн улмаас түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлдэггүй байна.
- 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 2 ширхэг модон барилга бодитой оршин байхгүй байгааг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлага өгсөн. Энэ тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тодруулга авахад тухайн модон барилга байрлаж байсан газрын эзэмших эрхийг баталгаажуулж холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон арга хэмжээ авч биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд гаргаж өгөх албан шаардлагыг тус байгууллагад ирүүлсэн байна.

Дээрхи 2 асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 албан шаардлага өгсөнөөс түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж боловсруулж, мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн 50.7 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Элэгдлээрээ өртгөө нөхсөн 38 нэр төрлийн 62.2 сая төгрөгийн анхны өртөгтэй, үндсэн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байгаа нь СТОУС-ын 17.49 “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ батламж мэдэгдлийн хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл: СТОУС-ын 17.49 “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай гэсэн заалт зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: 38 нэр төрлийн, анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг цаашид ашиглахаар бол дахин үнэлэх эсвэл акталж данснаас хасах асуудлыг ТӨБЗГ-т хандаж шийдвэрлүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Хуулийн хэрэгжилттэй холбоотой

3.2.1 Илрүүлэлт: Эрх бүхий байгууллагаас Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын захирлыг томилоогүй, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг ажиллуулж байгаагаас холбогдох гэрээг байгуулаагүй, 2019 оны үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагыг төлөвлөөгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна”, 20 дугаар зүйлийн 20.3-д “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө

боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Байгууллагын үндсэн үйл ажиллагаа алдагдах, хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө боловсруулж батлуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2019 онд захирлын үүрэг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажиллаагүй тул орлогын болон зардлын төлөвлөгөө батлуулж ажиллаагүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,780,857.21	3,661,769.72
1.1.2	Дансны авлага	50,755,704.00	131,405,412.00
1.1.6	Бараа материал	2,878,020.55	2,644,221.34
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	142,053,759.15	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	199,468,340.91	137,711,403.06
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,106,248,377.63	6,980,408,558.61
1.2.2	Биет бус хөрөнгө	137,472,832.56	137,374,778.50
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,243,721,210.19	7,117,783,337.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,443,189,551.10	7,255,494,740.17
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,635,794.97	165,000.00
2.1.1.3	Татварын өр	71,533,443.67	86,196,717.19
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,591,000.00	-
2.1.1.6	Хүүний өглөг	4,558,375.40	3,959,505.12
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	210,870,000.00	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,198,144.72	2,198,144.72
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	292,386,758.76	92,519,367.03
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	27,476,793.53	25,278,648.81
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	27,476,793.53	25,278,648.81
2.2	Өр төлбөрийн нийт дүн	319,863,552.29	117,798,015.84
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : - төрийн	258,725,643.10	258,725,643.10
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	307,921,881.30	307,921,881.30
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,710,365,712.49	7,710,365,712.49
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	100,931,461.00	100,931,461.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,254,618,699.08)	(1,240,247,973.56)
2.3.10	Тайлангийн үеийн	-	-
	Өмнөх үеийн	-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,123,325,998.81	7,137,696,724.33
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,443,189,551.10	7,255,494,740.17

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	20,290,375.00	24,628,117.00
2	Борлуулалтын өртөг	2,058,910.34	2,696,098.22
3	Нийт ашиг (алдагдал)	18,231,464.66	21,932,018.78
4	Түрээсийн орлого	260,470,452.12	374,039,125.58
8	Бусад орлого	-	210,870,000.00
9	Борлуулалт маркетингийн зардал	4,627,110.92	4,911,309.85
10	Ерөнхий ба удирдлагын зардал	341,332,989.28	436,419,288.95
11	Санхүүгийн зардал		3,554,346.07
12	Бусад зардал	3,761,338.82	145,988,726.69
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(71,019,522.24)	15,967,472.80
19	Орлогын татварын зардал	-	1,596,747.28
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(71,019,522.24)	14,370,725.52
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(71,019,522.24)	14,370,725.52
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	122,037,243.10	307,921,881.3	1,669,218,270.0	100,931,461	(1,179,040,801.44)	1,021,068,053.96
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(4,558,375.40)	(4,558,375.40)
3	Залруулсан үлдэгдэл						-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(71,019,522.24)	(71,019,522.24)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	136,688,400.00		6,041,147,442.5			6,177,835,842.50
9	2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	258,725,643.10	307,921,881.3	7,710,365,712.5	100,931,461	(1,254,618,699.08)	7,123,325,998.82
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
11	Залруулсан үлдэгдэл						-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					14,370,725.52	14,370,725.52
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт						-
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	258,725,643.10	307,921,881.3	7,710,365,712.5	100,931,461	(1,240,247,973.56)	7,137,696,724.34

4.4 Аудит хийсэн тайлан мөнгөн гүйлгээний тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	317,350,429.00	323,427,877.72
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсэний орлого	4,595,373.00	24,404,654.59
1.1.5	Татаас , санхүүжилтийн орлого	69,547,500.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	243,207,556.00	299,023,223.13
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	312,974,891.89	320,275,045.21
1.2.1	Ажиллагчдад төлсөн	132,580,510.20	147,280,177.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	36,874,392.09	42,593,868.83
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	22,480,641.44	12,278,557.04
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	55,680,134.73	77,908,549.88
1.2.5	Түлш шатахуун,тээврийн хөлс , сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,525,400.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	30,344,397.16	26,494,166.30
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	115,830.00	138,996.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	31,373,586.27	13,580,729.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,375,537.11	3,152,832.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	225,000.00	474,905.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	225,000.00	474,905.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(225,000.00)	(474,905.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,828,980.00	2,797,015.00
3.2.1	Зээл , өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,828,980.00	2,797,015.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,828,980.00)	(2,797,015.00)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,321,557.11	(119,087.49)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,459,300.10	3,780,857.21
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,780,857.21	3,661,769.72

4.5 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт		2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Зөрүү
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	590,870,000.00	609,537,242.58	18,667,242.58
1.1	Шинжилгээ, судалгаа, туршилтын орлого	25,000,000.00	24,628,117.00	(371,883.00)
1.2	Байрны түрээсийн орлого	355,000,000.00	374,039,125.58	19,039,125.58
1.3	Төсөл хөтөлбөрийн орлого	210,870,000.00	210,870,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)	596,863,019.03	593,569,769.78	3,293,249.25
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,700,000.00	2,696,098.22	3,901.78
2.2	Цалингийн зардал	185,956,967.96	178,482,431.96	7,474,536.00
2.3	НДШ	21,661,038.71	21,661,038.71	-
2.4	Цахилгааны төлбөр	35,437,970.00	38,586,281.44	(3,148,311.44)
2.5	Дулаан	21,998,467.43	24,099,857.11	(2,101,389.68)
2.6	Усны төлбөр	5,429,990.16	4,701,989.51	728,000.65
2.7	Харуул хамгаалалт	14,836,363.64	14,836,363.64	-
2.8	Төлбөр хураамж, даатгал сургалт	18,800,000.00	18,847,081.06	(47,081.06)
2.9	Төсөл хөтөлбөрийн зардал	145,988,726.69	145,988,726.69	-
2.10	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	133,503,494.44	133,503,494.44	-
2.11	Бусад зардал	10,550,000.00	10,166,407.00	383,593.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-5,993,019.03</u>	<u>15,967,472.80</u>	<u>15,373,993.33</u>

5. Зөрчлийн нэгтгэл

Огноо: 2020.03.10	Аудитын нэр: Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/110-СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци ТӨААТҮГ	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус газрын захирлыг томилоогүй, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг ажиллуулж байгаагаас холбогдох гэрээг байгуулаагүй, 2019 оны үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагыг төлөвлөөгүй байна		Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
2	Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн тэг үлдэгдэл өртөгтэй 38 нэр төрлийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй байна.	62.2	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
3	Шинжлэх ухаан паркийн захиргаа, шинжлэх ухаан технологи үйлдвэрлэлийн 2018, 2019 онуудын авлагаас төлөгдөөгүй ба тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, татварын өр өмнөх оноос өссөн байна.	49.3	Албан шаардлага өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
4	2016 онд баталж мөрдсөн НБББББ-т өөрчлөөгүй, түүнээс хойш гарсан хуулийн өөрчлөлт, заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй байна.		Албан шаардлага өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч, нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
5	Ажилтнуудын ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйгээс цалин давхардуулан олгосон байна.	1.4	Акт тогтоох	Захирлын үүрэг гүйцэтгэгч, нягтлан бодогч	П.Насанжаргал Ц.Ичинхорлоо
Нийт		112.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 16

№ 02/55

Улаанбаатар хот

С.ЯТ- 2020/110/СТА-ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ээлжийн амралтаа биеэр эдлээгүй хавсралтад дурдсан ажилтнуудад 1,426,156.00 төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13-т “Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтнуудад давхардуулан олгосон 1,426,165.00 /Нэг сая дөрвөн зуун хорин зургаан мянга нэг зуун жаран таван/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2020 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨААТҮГ –ын захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал, нягтлан бодогч Ц.Ичинхорлоо нарт даалгав.

АКТЫГ

ТОГТООСОН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР С.ОТГОНХОРЛОО
АУДИТОР З.ЦЭЦГЭЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
КОРПОРАЦИ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
П.НАСАНЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ Ц.ИЧИНХОРЛОО

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 16

№ 02/112

Улаанбаатар хот

саяг-2020/110/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шинжлэх ухааны паркийн захиргаа, шинжлэх ухаан технологи үйлдвэрлэлийн нэгдэл УТҮГ-аас 2018-2019 үүссэн түрээсийн төлбөрийн 34,778.1 мянган төгрөгийн авлагаас барагдуулаагүй болон тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, татварын өр өмнөх оноос 14,663.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж авлага өр төлбөрийг барагдуулах талаар ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨААТҮГ –ын захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал, нягтлан бодогч Ц.Ичинхорлоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
С.ОТГОНХОРЛОО
З.ЦЭЦГЭЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
КОРПОРАЦИ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
П.НАСАНЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ИЧИНХОРЛОО

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 16 № 02/113
СЯТ-2020/110/СТА-ТӨЧГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 оноос хойш шинэчлээгүй, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын өөрчлөлтүүдийг тусгаж мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн мөрдөх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци ТӨААТҮГ –ын захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал, нягтлан бодогч Ц.Ичинхорлоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
<p>ӨГСӨН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТОР <i>Ц.Наранчимэг</i> АУДИТОР <i>С.Отгонхорлоо</i> АУДИТОР <i>З.Цэцгээ</i></p>	<p>ЗӨВШӨӨРСӨН: ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН КОРПОРАЦИ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ П.НАСАНЖАРГАЛ НЯГТЛАН БОДОГЧ Ц.ИЧИНХОРЛОО</p>

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд" зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines providing a template for writing the summary.

